



“ ДАРХАН МИНЖ ” ХХК-НИЙ
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



2023 он

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

Батлав.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин,байгалийн
нөөцийн удирдлагын газрын даргын

_____ (Ц.Уранчимэг)

Зөвшөөрч,хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“ Дархан Минж “ ХХК Дэд захирал



“ ДАРХАН МИНЖ “ ХХК

Дарха –Уул аймаг,Дархан сумын 13-р багийн нутаг
дэвсгэрт байрлах арьс шир боловсруулах үйлдвэр

Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар..../ 1911050681 /
Аж ахуйн нэгжийн РД:...../ 2025043 /

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

_____ (П.Шинэцэцэг)

Хэрэгжилтийг гаргасан:

“ Дархан Минж” ХХК
ХАБЭА.БО,Дотоод хяналт хариуцсан ажилтан

_____ (Б.Хишигдэлгэр)

2023 он

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Товч танилцуулга

Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р баг, Үйлдвэрийн раойнд байрлах “Дархан Минж” ХХК нь 1992 онд үүсгэн байгуулагдаж, арьс шир нэхий боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр тасралтгүй 31 жил үйл ажиллагаа явуулж буй үндэсний үйлдвэрлэгч компани юм. тус компани нь 2022 онд 100000 ширхэг хонины нэхий, 50000 ширхэг савхи, 80000 ширхэг үхрийн шир боловсруулсан.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл: ААН нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар	Хаяг байршил
Дархан Минж ХХК	1911050681	2025043	Дархан Уул аймаг, дархан сум, 13-р баг үйлдвэрийн район

Үйлдвэрийн хүчин чадал

“ ДАРХАН МИНЖ” ХХК-ний арьс нэхий боловсруулах үйлдвэрийн нойтон боловсруулалтын үе шат нь түүхий эдийг годлох, махлах, тайрах, дэвтээлэг, тос авалт, угаалга, пикельдэх, идээлэх, тосолгоо, будах хуурай цехийн механик ажиллагаа хромлосон арьсны будагтай арьсны гэсэн дараалалтай боловсруулдаг.

Манай компани нь 2022 онд 100 000 ширхэг хонины нэхий, 150 000 ш үхрийн шир боловсруулахад нийт 46 нэр төрлийн химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөлтэй.

Тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн талаар

Боловсруулах үйлдвэрийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг түүвэр байдлаар 2019-2022 онд хийж, мэргэжлийн байгуулагаас ашиглах зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна. Ялангуяа цехийн тоног төхөөрөмжүүдийг шинэчилснээр, химийн материалын зарцуулалтыг 30% бууруулах ач холбогдолтойгоос гадна механик боловсруулалтын машинууд нь бүтээмжийг 2-3 дахин нэмэгдүүлж арьсны боловсруулалтын түвшинг сайжруулсан. 2020 онд үхрийн ширийг гүйцэт боловсруулах тоног төхөөрөмжийг шинээр худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Ажиллах хүчин

Нийт байнгын ажиллагсдын тоо 2023 оны байдлаар 65 байна.

Компанийн мэргэжилтнүүд Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олон жил ажилласан туршлагтай удирдлагын болон ажиллагсад ажилладаг.

Дэд бүтцийн хөгжлийн байдал**Зам**

“Дархан Минж” ХХК-ийн Дархан хот дахь үйлдвэр нь нийслэл хот, бусад аймгийн төвүүд, ОХУ, БНХАУ-ын хотуудтай төмөр зам ба автозамаар холбогдсон дэд бүтцийн хөгжил сайтай раойнд байрладаг.

Эрчим хүчний хангамж

Үйлдвэр нь Дарханы ЦШС-ний газраар дамжуулан 6 вольт хүчдэлтэй 2 талын тэжээлтэй шугамаар цахилгаан эрчим хүч авдаг бөгөөд үйлдвэр нь өөрөө трансформаторын дэд станцтай. Тоног төхөөрөмжийн

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

шинэчлэлт, сайжруулалт хийснээр цахилгааны хэмнэлт үүсэх эерэг талтайгаас гадна сүүлийн үеийн өндөр бүтээмжит овор ихтэй тоног төхөөрөмжүүдийг ажиллуулах шаардлагын үүднээс 2021 онд дэд станцад мэргэжлийн байгуулагаар урсгал засварын ажлыг бүрэн хийж, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэх, газардуулагад холбох, мэргэжлийн байгуулагаар хэмжилт хийлгэж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Дулаан хангамж

Үйлдвэрлэлийн 5800м² дулааныг хотын дулааны шугам сүлжээнээс авч хэрэглэдэг. Үйлдвэр ашиглалтанд ороод 30 гаран жил болж буй учир дулаан, сантехник барилга засварын капитал засвар хийх шаардлагатай болсон учраас засварын хэсэгчилсэн ажлууд эхэлж барилга засварын ажлудыг хийж байна.

Цэвэр усны хангамж

Тус үйлдвэр нь Дархан хотын усан хангамжийн төвлөрсөн системийн шугам сүлжээнээс унд, ахуйн цэвэр усыг авч хэрэглэдэг.

Үйлдвэрийн бохир усны систем

Шир боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд цэвэрлэх байгууламжийг шинээр 2020 онд бохир усыг Европын стандартаар цэвэрлэх иж бүрэн байгууламжийг ашиглалтанд оруулсан.

Агаарын бохирдол

Дархан сумын агаарын бохирдол 2022 оны байдлаар азотын давхар ислийн дундаж 0.022мг/м³ буюу агаар дахь агууламж нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй болно.

Хөрс

Дархан орчмын нутаг нь Орхон, Сэлэнгийн сав газрын хар хүрэн хөрс зонхилсон талархаг өргөн хөндийг төлөөлөх бөгөөд энд Хараа голын хөндий рүү намсаж буусан гүвээрхэг нам уулс, ам хөндийн өндөрлөг болон тэгшивтэр хэсгээр харилцан адилгүй зузаан ялзмагт давхаргатай, карбонат давхарга нь янз бүрийн гүнд илэрдэг хар хүрэн хөрс голлон тархсан.

Технологийн үндсэн дамжлага ба процесс

“Дархан Минж” ХХК-ийн Арьс, нэхий боловсруулж бүтээгдхүүн үйлдвэрлэх үйлдвэр нь химийн аргаар нойтон боловсруулах, механик аргаар гүйцээн боловсруулах үйлдвэрлэл явуулдаг. Энэ нь технологийн хувьд нэг нь нөгөөгөөс хамаарсан дамжлага хэлбэрийн үйл явц байдаг.

Үйлдвэрийн шингэн хаягдал

Арьс, нэхий боловсруулах үйлдвэрийн хувьд, арьсанд анхан шатны боловсруулалт хийх, арьсыг боловсруулах, эцсийн бүтээгдхүүн үйлдвэрлэх явцад бохир ус ялгарч гарна. Гэхдээ энэ бүгд дамжлагаас гарах бохир шингэн нь ихэнхдээ анхдагч боловсруулалтын үйлдвэрлэлийн үед хортой нөлөө нь зонхилно.

Боловсруулж буй арьс нь технологиос хамааран, зарцуулагдах хольц нэгдлийн хэмжээ, нэр төрлөөр ялгагдана.

Арьс ширний үйлдвэрээс гарах бохир ус нь:

- Арьс ширийг дэвтээх, угаах
- Арьс ширний үсийг унагах
- Арьс ширийг идээлэх
- Идээлсэн арьс ширийг угаах, хатаах зэрэг дамжлагуудаас гарна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Арьс ширийг боловсруулахад үйлдвэрийн бохир ус нь дараахь химийн найрлагуудыг агуулсан байдаг.

- Их хэмжээгээр булингартсан
- Олон төрлийн өнгө
- Саармагжуулсан
- Их хэмжээний өөх
- Илүүдэл давс болон химийн бодис
- Махлах машинаас гарч байгаа хог хаягдлыг зориулалтын хогын цэгт хаяна.

Мөн “Дархан Минж” ХХК үйлдвэрийн ахуйн хэрэгцээний багагүй хэмжээний ус (ажилагсдын цайны газар, ахуйн бохир усны шугам сүлжээ зэргээс) бохир усыг нэмэгдүүлж байгаа билээ.

Бохир ус цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламжийн талаар

Үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн гол үүрэг нь арьс нэхий боловсруулсан үйлдвэрийн бохирдолтой уснаас химийн бодисыг шүүж, ялган, хоргүйжүүлсний дараа бохир усыг төвийн систем рүү нийлүүлэх явдал юм.

Тус үйлдвэрийн цэвэрлэх байгууламж нь механик ба химийн аргаар хоногт **800 м³** бохир ус цэвэрлэх хүчин чадалтай.

Уг цэвэрлэх байгууламж ашиглалтанд оруулснаар химийн бодис болох хромын цэвэрлэгээг иж бүрнээр хийж, байгаль орчинд ээлтэй эко цэвэр үйлдвэрлэл явагдах эх үүсвэр тавигдсан.

Хатуу хог хаягдал

Хуурай хог хаягдлыг түүхий эдийн арьс годолгоо , арьс боловсруулалтын үеийн захалгаа, бусад хог хаягдал гэж хуваан үзэж болно.

Боловсруулалтын үеийн хог хаягдалд арьс шир бэлтгэлийн үед малын арьстай хамт тушаагдсан шийр тагалцаг, мөн боловсруулалтын үед хяргагдсан урт, богино ноос, хуурай хог хаягдалд хяргагдсан урт ноос, хээл, хүзүүний зузаан хатуу арьс орох ба бусад хог хаягдалд байгууллагын үйл ажиллагааны явцад гарах хуурай хог хаягдлууд орно.

Хуурай хог хаягдлыг үйлдвэрийн хашаан дахь хогийн цэгт цуглуулж, НААҮГ-тай хог тээвэрлэлтийн гэрээ хийгдэж, тээвэрлэн Дархан хотын хогийн төвлөрсөн цэг болох үйлдвэрийн районоос 8км, хотын төвөөс 16-17км зайд орших газарт устгалд оруулдаг.

Төслийн товч болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх болон түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийж гүйцэтгэх ажил, шаардагдах зардлыг тооцож тусгасан.

Болзошгүй сөрөг нөлөөлөлд химийн бодис алдагдах, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөнөөс үйлдвэрийн осолд өртөх, цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагаа алдагдсанаас бохир усан дахь хог хаягдалыг шүүх боломжгүй болох, газрын ашиглалтаас үүдэх хөрсний элэгдэл, эвдрэл, агаарын бохирдлоос үүсэх хөрсний бохирдол зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх нөхцөл бий болж болзошгүй юм.

Эдгээр болзошгүй нөлөөлөл бий болсоноор байгаль орчин бохирдоод зогсохгүй, хүний эрүүл мэнд амь насанд сөрөгөөр нөлөөлөх үндэс суурь болдог юм.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь хог хаягдлын менежментийг сайжруулах, хөрсний бохирдлыг саармагжуулах арга хэмжээг боловсруулах, ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, орчны шинжилгээний хяналтаар илэрсэн сөрөг нөлөөллийг бууруулах, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, арга замыг төлөвлөсөн байсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨӨГӨӨ

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах аргахэмжээ	Үр дүн	Хугацаа	Зарцуулах мөнгөн дүн/төг
1. АГААРЫН ЧАНАР				
ШБҮйлдвэрийн зүлгүүрийн машинаас гарч байгаа хог хаягдал нь хөрс болон агарын бохирдолыг үүсгэж байгаа	Хог хаягдалыг хадгалах шийдлийг олох	Тоосжилт, хаягдал багасах	2023 1-р улирал	250.000
Уурын зуухны үнсний тоосжилт өндөр байгаа нь агаарын бохирдол үүсгэж байна	Мэргэжлийн байгуулагаар хэмжилт хийлгүүлж, арга зүйн зөвлөмж авах	Агаар дахь тоосжилт бууруулах	2023 оны 2-р улирал	100.000
Өнгө заслын ажлын байрны агааржуулалт нь ажлын байрны агаарын бохирдолыг их хэмжээгээр үүсгэж байна	Байгалийн гаралтай агааржуулалтыг нэмэгдүүлэх	Агаарын солбилцол сайжрах	2023 оны 2-р улирал	350.000
Цэвэрлэх байгууламжийн агаар дахь хорт хийг хэмжих төхөөрөмж эвдэрсэн нь аюул эрсдэлийг дагуулж байна	Суурин хэмжих төхөөрөмжөөр хангах, баталгаажуулалтыг хугацаанд нь тогтмол хийлгэсэн байх	амь нас эрүүл мэнд хамгаалах	2023-2-р улирал	1.000.000
2. ГАЗРЫН ДООРХ УС				
Цэвэрлэх байгууламжийн насосны хүчин чадал бага байгаагаас бохир усаа удаан шүүж халих зэрэг зөрчил үүсэж байна	Цэвэрлэх байгууламжинд ажиллах насосны хүчин чадалыг нэмэгдүүлэх, гацсан шнекийг засварлуулах	Байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх	2023 оны 3-р улирал	1.500.000
Нийт				3.200.000

2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн үндсэн түүхий эд байгалийн баялаг бус малын гаралтай түүхий эд болох тул байгалийн бүрэлдэхүүн хэсгийн нөхөн сэргээлтний асуудал энд яригдахгүй харин орчны цэцэрлэгжүүлэлт, хөрсний эвдрэлийн талаар төлөвлөнө.

Д/д	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Осол эрсдэлийг бууруулах	Үр дүн	Хугацаа	Зарцуулах мөнгөн дүн /төг
1	ШБҮ-ийн барилгын баруун талийн зөөлөн хөрслөг	Цэвэрлэгээ хийх, хог хаягдлыг хаяж устгах	Хөрсний бохирдлыг бууруулах	2023-3-р улиралд	500.000
2	Ногоон байгууламжийн ургалт хангалтгүй байна	Мэргэжлийн байгуулагаас зөвлөгөө авах	Ногоон байгууламжийн өнгө үзэмж нэмэгдүүлэх	2023-2-р улиралд	150.000
3	Өндөр хүчдэлийн трансформаторийн хашаанд налж ургасан мод нь галын аюулд өртөх	Тохиромжтой хугацаанд нь мэргэжлийн байгуулагаар тайруулах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх	2023-2-р улиралд	50.000
Нийт					700.000

3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Зарцуулах мөнгөн дүн / төг
1	Гол, уст цэгүүдийг ахуйн болон үйлдвэрийн хог хаягдалаас цэвэрлэх ажлыг зохион байгуулах	200.000
2	ШБҮ-н баруун талын хэсгийг эмхэлж цэгцлэх	500.000
Нийт		700.000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө” осол аваарь гарсан тохиодолд төлөвлөнө

5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн талбай, түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс тэмдэглэгдээгүй тул үйл ажиллагаа явуулах үед “Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө” тусгайлан боловсруулах шаардлагагүй.

6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Осол, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээ	Хугацаа	Зарцуулах мөнгөн дүн/төг
1	Химийн материалын агуулахын хаалга нь усны хамгаалалт хангалтгүй	ШБҮ-н том хаалгаар ус орох нөлөөг бууруулах	2023 оны 2-р улиралд	500 000
2	Тусгайлан хадгалсан химийн аюултай хоосон сав баглаа боодлын хадгалалтын эмх цэгц хангалтгүй	Хаягжуулан, тусгаарлаж тоо хэмжээг гаргах	2023 оны 6-р сар	150.000
3	Химийн материалтай харьцаж ажиллаж байгаа ажилтаныг сургалтанд хамруулах	Сургалтанд хамруулж шалгалт авах	2023 оны 3-р улирал	120.000
4	Химийн материалтай харьцдаг ажилчид химийн материалд хордох	Ажилчидад өдөр бүр хор саармагжуулах ундаа олгох	Жилийн турш	1000 000
Нийт				1.770. 000

7. ОСОЛ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Осол, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээ	Хугацаа	Зарцуулах мөнгөн дүн/төг
1	Ажиллагсадын анхаарал болгоомжгүйгээс ажлын байрны осол гарах аюул	Дотоодын хяналт шалгалтыг сайжруулах, холбогдох хууль дүрмийн танилцуулга, сургалт сурталчилгааг тогтмол хийх	Жилийн турш	500.000
2	Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүйгээс гарах эрсдэл	Илэрсэн зөрчлийг шуурхай мэдээллэх, газардуулгын даацын баталгаажуулалтыг цаг хугацаанд нь хийлгэх	2023-5 сард	500.000
3	Аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөөгүйгээс гарах эрсдэл	ХАБЭА-н шинэчлэгдсэн дүрэм журмыг таниулах сурталчилах, сургалт зохион байгуулах	Жилийн турш	Зардал гарахгүй
4	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийгээгүйгээс осол эндэгдэл гарах	Ажлын байр бүрт үнэлгээ хийх	2023-10 сард	500.000
5	Ажлын байрны орчин нөхцөл, аюулгүй тав тухтай орчиныг бүрдүүлээгүйгээс болж гарах аливаа эрсдэл	ШБҮ-н дээвэрт үзлэг хийж, цоорхой завсар зай байвал нөхөх бөглөх	2023-8 сард	250.000
6	Ажлын байрны дуу шууиан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн	Хэмжилт хийж, ЗДХ-с хэтэрсэнг бууруулах арга хэмжээ авах	Жилийн турш	150.000
Нийт				1900.000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

8. ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Болзошгүйсөрөгнөлөөлөл	Осол, эрсдэлийгбууруулах, арилгахаргахэмжээ	Хугацаа	Зарцуулах мөнгөн дүн/ төг
1	Хог хаягдлыг тогтмол хугацаанд устгал хийгдээгүйгээс агаар, хөрс, усыг бохирдуулах сөрөг нөлөөлөл учруулах	Хог хаягдлыг тогтмол хугацаанд хяналт тавьж устгуулж байх	Жилийн турш	1. 000. 000
2	Хог хаягдлын устгалд хяналт тавьж бүртгэл хөтлөөгүйгээс нийт хог хаягдлын хэмжээг тодорхойгүйгээс зарцуулах зардал хяналтгүй болох	хог хаягдлын бүртгэлийн тоо хэмжээг гаргах, хяналт тавих ,	Сар бүр	Зардал гарахгүй
3	Хог хаягдлыг ангилан ялгаагүйгээс эмх замбараагүй хогын цэг бий болох	Орчны цэвэрлэгээг хувиарын дагуу тогтмол цэвэрлүүлэх, хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, ашиглаж болохоор хогыг ялган хураах	Жилийн турш	Зардал гарахгүй хариуцсан үйлдвэрүүдэд эр цэвэрлэгээг хийлгэх
Нийт				1. 000 .000

9. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх ажлын нэр	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Зарцуулах мөнгөн дүн/төг
1	Аюул осол гарахаас урьдчилан сэргийлэх ажлын арга барилд сургах	Цехийн аюулгүй ажиллагаанд тогтмол хянах	2023 тогтмол	ХАБЭА	Зардал гарахгүй
2	Ажиллагсадыг урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Мэргэжлийн газартай гэрээ байгуулан гэрээний дагуу арга хэмжээ авах	2023-10сард	Мэргэжлийн байгуулаагатай гэрээ байгуулан	1. 500.000
Нийт					1.500.000

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд хяналт тавих үзүүлэлтүүдийг тогтоож, сорьц дээж авах цэгийн байршил, шинжилгээ хийх үзүүлэлтүүд, хугацаа, давтамжийг тодорхойлон хяналт-шинжлээний ажлын үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож тусгав.

д/д	Хяналт шинжилгээ хийх хөтөлбөрүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Зарцуулах мөнгөн дүн/төг
1	Агаарын чанарын шинжилгээ	Үйлдвэрийн хашаанд 3-н цэгээс	2023-сар бүр	65 000
2	Хөрсний шинжилгээ	Бохирдсон хөрсөнд, үйлдвэрийн баруун, зүүн, хойд гэх өөр 3 цэгт	2023-сар бүр	120 000
3	Усны шинжилгээ	Үйлдвэрийн бохир усны дээж	Сар бүр	Төлбөргүй
Нийт				185.000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

д/д	Хэрэгжүүлэх ажлын нэр	Хэрэгжих газар	Хугацаа	Хариуцах эзэн
1	БОМТ-г 2023.10 сард Аймгийн ажлын хэсэгт тайлагнаж батлуулах	Үйлдвэрийн хэмжээнд	2023-2024	Дархан Минж ХХК-Дэд захирал, БО ажилтан
2	Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум ,багийн иргэдийн нийтийн хуралд “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар танилцуулага хийх	13-р багийн иргэдэд	2023онд	Дархан Минж ХХК-захирал, БО ажилтан
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч,Төрийн захиргааны болон БО-ны төрийг бус байгуулагуудаас хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах	Үйлдвэрийн хэмжээнд	2023 онд	Удирдах ажилтнууд

12. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын төсөв	Хариуцах эзэн
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал	3.200.000	Байгаль орчны ажилтан
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	700.000	Байгаль орчны ажилтан
3	Дүйцүүлэн хамгаалах	700.000	ХНМ
4	Нүүлгэн шилжүүлэх	0	
5	Түүх соёлын өвийг хамгаалах	0	
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1.770.000	ХАБЭА, Химийн нярав
7	Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1.900.000	ХАБЭА, Дотоод хяналт
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.000.000	Санхүү Дотоод хяналт
9.	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага ,зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	1.500.000	Удирдах ажилтан Дотоод хяналтын багш
10.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	185.000	Байгаль орчны ажилтан
11	НИЙТ ЗАРДАЛ	10.955.000	

2023 он

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө